



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2024 оны 02 дугаар сарын дугаар



“Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



"Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/99 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ын дагуу “Тонж логистик” ХХК-д 2024.02.26-ны 132, 133 дугаартай албан бичгээр түрээсийн 23 хагас, 7 битүү вагоныг мэдээллийн санд тус тус бүртгэсэн.




ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв

ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ 2024.02.28

ЭЗЭМШЛИЙН ЗҮТГҮҮР МАШИН МЕХАНИЗМ



ТҮРЭЭСИЙН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН



ЭЗЭМШЛИЙН ВАГОНУУД



НИЙТ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

ЗҮТГҮҮР – 190
МАШИН МЕХАНИЗМ – 83
ЗОРЧИГЧИЙН ВАГОН – 321
ХАГАС ВАГОН – 6982
ТАВЦАНТ ВАГОН – 1642
БУСАД – 2345 (цистерн, битүү, дозатор, ледник, думпкар, хоппер, зерновоз, өөрч.тоноглогдсон.)

Тайлбар: 2 хуулийн этгээдийн түрээсийн 7 битүү, 100 хагас вагоныг бүртгэсэн байна.

**НИЙТ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН
12360**

Мэдээ, мэдээлэл



Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд:



Төвийн захирлын 02 дугаар сарын 16-ны өдрийн А/06 дугаар тушаалын 1-р хавсралтаар “Төмөр замын үйл ажиллагааны объектуудын байршлын нэгдсэн код олгох заавар”-ыг, 2 дугаар хавсралтаар ажлын хэсгийн батлуулсан. Мөн өдрийн 100 тоот албан бичгээр “ТТЗ” ХХК-д төмөр замын үйл ажиллагааны кодыг олгож,

ТЗДТБЗГ-т албан бичгээр заавар болон кодыг хүргүүлсэн. 2 дугаар сарын 26-ны өдрийн 135 тоот албан бичгээр “МТЗ” ТӨХК-д үндсэн кодыг олгосон. “УБТЗ” ХНН-ийн ашиглагдаж байгаа өртөө зөрлөгүүдийн кодуудыг мэдээллийн сан үүсгэн бүрдүүлж байна. Нэгдсэн технологийн горимыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан СБЭ хооронд тээвэрлэлт хийхэнд гарч буй хүндрэл, шийдвэрлүүлэх асуулдууд, төлөвлөсөн ажлын талаар мэдээлэл авахаар албан тоот хүргүүлсэн.



Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд:



ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны их сургуульд суралцаж буй магистрын эчнээ ангийн 1 дүгээр курсийн оюутнуудыг 2024.01.28-02.20-ны хооронд хичээлд бүрэн хамруулж, с у р г у у л ь , о ю у т н у у д ы г ш а а р д л а г а т а й м э д э э л л э э р х а н г а н а ж и л л а с а н .


ОХУ-ын Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Дээд боловсролын салбарын бодлогын 2024/2025 оны элсэлтийн хичээлийн жилд нэмэлт мэргэжил, боловсролын сургалтын хөтөлбөрт төмөр замын салбарын 14 ажилтан, албан хаагчдын бүртгэлийг хийж, өргөдөл илгээгч нарын баримт бичгийг бүрдүүлж, ярилцагад хамруулсан. МНГ кодыг РЦНК болон ИрГУПС-д хүргүүлж хөтөлбөрт 13 хүнийг хамруулсан.





Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас:

Явуулсан 85 бичгийн 58 буюу 68.2 хувийг, ирсэн 34 бичгийг 100 хувь системд байршуулсан. Төвийн хэмжээнд 1-р сард баримт бичиг хянан шийдвэрлэсэн тайланг шинэчлэн дахин боловсруулав. Тайлант сард 52 хариутай бичиг ирснээс хугацаанд



нь шийдвэрлэсэн 47, шийдвэрлэгдэх шатанд 1, хугацааг сунгасан 3, хариу өгөөгүй 1, шийдвэрлэлт 90.4 хувь. Төвийн хэмжээнд 2-р сард баримт бичиг хянан шийдвэрлэсэн тайлан, мэдээг 2024.02.28-ны өдөр гаргасан. Тайлант сард 23 хариутай бичиг ирснээс хугацаанд нь шийдвэрлэсэн 14, шийдвэрлэгдэх шатанд 5, хугацаа болоогүй 2, хариу өгөөгүй 2, шийдвэрлэлт 66.7 хувь. Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн болон хариу ирээгүй бичгийн мэдээг 6 удаа гаргасан. Төвийн хэмжээнд шийдвэрлэх хугацаа хэтэрсэн 3 бичиг байна. Төвөөс 1-р сард явуулсан хариу ирүүлбэл зохих бичгээс хариу ирээгүй 13, 2-р сард явуулсан бичгээс хариу ирээгүй 12, хугацаа болоогүй 20 бичигтэй 33.3 хувьтай байна.

Сайдын 2024.02.08-ны өдрийн 03 дугаар шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар ЗТХЯ-ны ТЗУГ-аас 2024.02.14-ний өдөр цахимаар ирснийг RTCC viber группт байршуулж нийт ажилтанд мэдээлсэн. Сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2024.02.01, 2024.02.16, 2024.02.22, 2024.02.29-ний өдөр яамны ТЗУГ-т цахимаар, 2024.02.16-ны өдөр (№98) албан бичгээр тайлагнасан. Сайдын ээлжит шуурхай хуралдаан 3 удаа хойшлогдсон мэдээллийг төвийн захиралд 2024.02.07, 2024.02.16, 2024.02.27-ны өдөр цахимаар мэдээлсэн. Нэгжүүдийн сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж тайлангаар санал зөвлөмжийг өгч удирдлагад танилцуулж эйбл системд 2024.02.08-ны өдөр байршуулж мэдээлсэн.

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж тайлангаар санал зөвлөмжийг өгч удирдлагад танилцуулж эйбл системд 2024.02.08-ны өдөр байршуулж мэдээлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын сургалтад хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, хуулийн мэргэжилтэн нар 2024.02.02-ны өдөр

Мэдээ, мэдээлэл



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд хоногийн 300 мэдээ, сарын 24 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам", ЗТХ-ийн 2021 оны "Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай" А/93 дугаар тушаалын хүрээнд ЗТХЯ-нд сарын статистик мэдээг албан бичиг болон цахим шуудангаар хүргэж тайлагнасан. Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2024 оны 1 дүгээр сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн.



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн
зохицуулалтын нэгдсэн төв

АЧАА, ТЭЭВРИЙН СТАТИСТИК МЭДЭЭ

1 СУУРЬ БҮТЭЦ ЭЗЭМШИГЧЭЭР ТЭЭВЭРЛЭСЭН АЧААНЫ МЭДЭЭ /ТОННООР/



2 947 200 тн ❖ Импорт: 357 400 тн ❖ Дамжин өнгөрсөн: 433 300 тн
Үүнээс: ❖ Экспорт: 902 000 тн ❖ Орон нутаг: 1 254 500 тн



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

Төмөртэй өртөө: 19 753 тн
Үүнээс:
❖ Төмрийн хүдэр: 19 753 тн
Цогтцэций өртөө: 112 049 тн
Үүнээс:
❖ Экспорт: 33 645 тн
❖ Импорт: 24 279 тн
❖ Мидлинг: 54 125 тн



171 120 тн
Үүнээс:
❖ Нүүрс: 140 290 тн



❖ Төмрийн хүдэр: 312 490 тн
❖ Нүүрс: 37 170 тн

2 ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ [хүн]

Зорчигч тээвэрлэлт: 165 100 хүн
Үүнээс:
❖ Олон улс: 2 200 хүн
❖ Орон нутаг: 162 900 хүн

3 ЧИНГЭЛЭГ ТЭЭВЭРЛЭЛТ

Чингэлэг тээвэрлэлт: 639 798 тн
Үүнээс:
❖ Импорт: 68 605 тн
❖ Экспорт: 223 263 тн
❖ Орон нутаг: 20 329 тн
❖ Транзит: 327 601 тн

Мэдээ, мэдээлэл




Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг танилцуулах


2024 оны 01 дүгээр сарын зурмагийн тасалдлын тайланд дүн шинжилгээ хийж, тайланг СХГ-т 2024.02.07 өдрийн 90 дугаарын албан бичгээр хүргүүлж ажилласан. Нэгдсэн зурмагийн 2023 он, 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, суурь бүтцүүдэд 2024.02.05, 2024.02.16 өдрүүдэд 87, 106,107,108,109,110 дугаарын албан бичгээр хүргүүлэн танилцуулж, ТЗДТБЗГ-д 2024.02.07, 2024.02.16 өдрийн 89,104 дугаарын бичгээр хүргүүлэн танилцуулсан



НЭГДСЭН ЗУРМАГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ (эхний 15 хоногор)



НЭГДСЭН ЗУРМАГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ (сүүлийн 14 хоногор)



ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭРЛЭЛИЙН ХОНОГИЙН ШУУРХАЙ МЭДЭЭ

№	Үзүүлэлт	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Залгах хувь	
1	Тээвэрлэлтийн төрлөөр	Үүнээс	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	мян.тн	10,245	8.6
			Ачаа гаргалт /экспорт/	мян.тн	41,130	34.4
			"УБТЗ" ХНН	мян.тн	32,862	79.9
			"МТЗ" ТӨХХ	мян.тн	0,000	0.0
			"ТТЗ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛож" ХХХ	мян.тн	8,268	20.1
			Ачаа оруулалт /импорт/	мян.тн	15,583	13.0
			Дотоод тээвэрлэлт /орон нутаг/	мян.тн	52,729	44.1
			Нийт	мян.тн	119,687	
2	Байгууллагаар	Үүнээс	"УБТЗ" ХНН	мян.тн	94,365	78.8
			"МТЗ" ТӨХХ	мян.тн	4,672	3.9
			"ТТЗ" ХХХ	мян.тн	12,382	10.3
			"МТЛ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛож" ХХХ	мян.тн	8,268	6.9
			Нийт	мян.тн	119,687	
3	Хилийн өртөөний галт тэрэг солилцоо	Үүнээс	Замын-Үүд / өргөн цариг /	Хос галт тэрэг	15	50.0
			Замын-Үүд / нарийн цариг /	Хос галт тэрэг	7.5	25.0
			Сүхбаатар / өргөн цариг /	Хос галт тэрэг	7.5	25.0
			Нийт	Хос галт тэрэг	30	

2024.02.27 17:00 цагаас 2024.02.28 17:00 цаг хүртэл




ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭРЛЭЛИЙН ХОНОГИЙН ШУУРХАЙ МЭДЭЭ

№	Үзүүлэлт	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Залгах хувь	
1	Тээвэрлэлтийн төрлөөр	Үүнээс	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	мян.тн	9,876	9.2
			Ачаа гаргалт /экспорт/	мян.тн	44,771	41.8
			"УБТЗ" ХНН	мян.тн	29,847	86.9
			"МТЗ" ТӨХХ	мян.тн	0,000	0.0
			"ТТЗ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛож" ХХХ	мян.тн	14,824	33.1
			Ачаа оруулалт /импорт/	мян.тн	11,304	10.6
			Дотоод тээвэрлэлт /орон нутаг/	мян.тн	41,089	38.4
			Нийт	мян.тн	107,041	
2	Байгууллагаар	Үүнээс	"УБТЗ" ХНН	мян.тн	85,556	79.9
			"МТЗ" ТӨХХ	мян.тн	4,672	4.4
			"ТТЗ" ХХХ	мян.тн	1,988	1.9
			"МТЛ" ХХХ	мян.тн	0,000	0.0
			"МТЛож" ХХХ	мян.тн	14,824	13.8
			Нийт	мян.тн	107,041	
3	Хилийн өртөөний галт тэрэг солилцоо	Үүнээс	Замын-Үүд / өргөн цариг /	Хос галт тэрэг	15.5	51.7
			Замын-Үүд / нарийн цариг /	Хос галт тэрэг	7.5	25.0
			Сүхбаатар / өргөн цариг /	Хос галт тэрэг	7	23.3
			Нийт	Хос галт тэрэг	30	

2024.02.28 17:00 цагаас 2024.02.29 17:00 цаг хүртэл



Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ны Дорноговь аймгийн газард ЗБ-СШ өртөө хооронд шилэн кабелийн урсгал, шөрмөс түрээслэхтэй холбоотой 2024.01.29-ны 09 дугаартай албан хүсэлт хүргүүлсэн. Тус компани нь 2024.02.05-ны өдөр МХС-ний Зүүнбаян салбарын байраас дохиолол холбооны 3-р анги хүртэл шилэн кабелийн шөрмөс болон урсгал гаргах бүрэн боломжтой гэж хариу ирүүлсэн. Мөн урсгал болон шөрмөс түрээслүүлэхтэй холбоотой урьдчилсан үнийн саналыг цахим шуудангаар хүлээн авсан. Тус мэдээллийг нэгтгэн КОЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт 2024.02.26-ны 138 тоот албан бичгээр хүргүүлэн танилцуулсан.



Авто тээвэрт ашиглагдаж буй "Цахим гэрчилгээ RFID шошго, уншигч суурилуулах" системийн ТЭЗҮ, Суурилалтын зураг төсөл, Архитектурын бүтэцтэй танилцаж төмөр замын салбарт шууд ашиглах боломжгүй гэж урьдчилан дүгнэв. ЗТХЯ-нд 2024.02.14-ний 95 дугаартай албан бичгээр хөдлөх бүрэлдэхүүнд RFID шошго суурилуулах, шаардлагатай цэгүүдийг

RFID уншигч бүхий иж бүрэн нэгжээр тоноглох шийдэл бүхий төлөвлөгөө, шаардагдах төсвийг танилцуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдад 2024.02.16-ны өдөр "Чиглэл хүсэх тухай" 112 дугаартай албан бичгээр БНХАУ-ын Харбины төмөр замын судалгааны институтын RFID шошго /tag/, БНСУ-ын КОЙКА-гийн RFID шошго /tag/ суурилуулахад шаардлагатай зардлын харьцуулалт болон КОЙКА-гаас ирүүлсэн албан бичгийг хүргүүлсэн. RFID буюу Хөдлөх бүрэлдэхүүнийг таних технологийн техникийн ерөнхий шаардлагын ажлын даалгавар V.01 - 2024.02 (анхан шатны хувилбар)-ыг боловсруулж эхэлсэн;



**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

